

“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

/2022 оны байдлаар/

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв /сая төгрөгөөр/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/
				Он	Түвшин		
<p>Зорилт 1.4. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж, нийтийн хүртээл болгон хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.</p>							
1.4.6.	Монгол хүний ёс суртахууны хэм хэмжээний талаарх судалгааг өргөжүүлэн хүүхэд залуус, төрийн албан хаагч, хууль, хүчний байгууллагын ажилтны ёс суртахууны нарийвчилсан судалгааг хийнэ.	-	Сахилга, хариуцлагын зөвлөгөөн зохион байгуулах (тоогоор)	2021	1	2022 онд 1	<p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг энэ оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор сахилгын зөрчлийн бодит жишээн дээр тулгуурласан богино хэмжээний 42 киног бэлтгэн алба хаагчдын “Чөлөөт индэр” фэйсбүүк группэд цувралаар байршуулж, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч, ажилтны ёс суртахуун, ёс зүйн байдлын талаарх үргэлжилсэн судалгааг 23 асуулттай боловсруулж, 18 сарын хугацаатай 2022 оны 10 дугаар сарын 17-н өдрөөс эхлүүлэн явуулж, цахимаар цагдаа, дотоодын цэргийн 56 анги, байгууллагад хүргүүлэн 5140 алба хаагчийг хамруулан судалаганы SPSS програмд мэдээллийг оруулан тоон боловсруулалт хийгдэж байна.</p> <p>Мөн алба хаагчдын ажлаас халшрах хам шинж, нойргүйдэл, стресс, сэтгэл гутрал, сэтгэл түгшүүр тогтвор суурьшил, сахилгын байдалд нөлөөлж буй хүчин зүйл зэрэг 7 төрлийн судалгаа хийж, цахимаар 1024 алба хаагчаас судалгаа авахад 74 алба хаагч буюу 7.2 хувь нь ажлаас халшрах өндөр өөрчлөлттэй, 103 алба хаагч буюу 10.1 хувь нь ажлаас халшрах мэдэгдэхүйч өөрчлөлттэй, 203 алба хаагч буюу 19.8 хувь нь ажлаас халшрах хам шинжийн үзүүлэлт дунд зэрэг, 554 ала хаагч буюу 54.1 хувь нь ажлаас халшрах хам шинжийн бага зэргийн өөрчлөлттэй, 729 алба хаагч буюу 71.1 хувь нь ямар нэг өөрчлөлтгүй хэвийн гарсан.</p>

							<p>Судалгааны үр дүнг үндэслэн нойрны хэм алдагдалтай, архаг ядралаас үүдэлтэй ажил мэргэжлийн гажуудал үүсч болзошгүй, стрессийн шалтгаант сэтгэл зүйн асуудалтай 137 алба хаагчаас 122-ийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн урьдчилсан үзлэг, оношилгоонд хамруулан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “стрессийн шалтгаант мэдрэлийн ядаргааны тасаг”-т 17, Наркологийн эмнэлэгт 12, “Рехамед Гялс” нэгдсэн эмнэлэгийн мэдрэлийн ядаргааны тасагт 30, нийт 59 алба хаагч эмчлүүлээд байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
<p>Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлнэ.</p>							
7.3.1.	Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, зарим аймгийн төв болон хүн амын суурьшилд, иргэдийн хөдөлгөөний нягтаршилт ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг хамгаалалтад авч, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Хамгаалалтад авсан объект (тоогоор)	2020 он	2	2022 он 7	<p>Улаанбаатар хотын ус хангамжийн Дамбадаржаагийн усан сан, Толгойтын усны эх үүсвэр, Яармагийн усны насос станц, Алтай хотын ус хангамжийн эх үүсвэр, Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Тайширын усан цахилгаан станц, Дарханы “Үндэсний дата төвийн нөөц төв” стратегийн орд, нийт 6 объектыг Дотоодын цэргийн хамгаалалтад авсан.</p> <p>“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц”-ыг 2023 онд дотоодын цэргийн хамгаалалтад авахад шаардагдах орон тоо, зардлыг шийдвэрлүүлэхээр 2022 оны 01/360 дугаар албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
7.3.6	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн	-	Хөтөлбөрийн нийт хэрэгжилтийг тайлагнах. (Хувиар)	2021	80%	2022 онд 100%	<p>Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, мөн оны 148 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн нийт хэрэгжилт, үр нөлөөний үнэлгээний мэдээллийг бэлтгэж энэ оны 06 дугаар сарын 20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахимаар хүргүүлсэн.</p>

	худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна.						<p>“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжсэнээр 2016 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой 98 гэмт хэрэгт 224 сэжигтэн холбогдон шалгагдаж байсан бол 2021 онд 187 гэмт хэрэгт 210 сэжигтэн холбогдон шалгагдсан нь гэмт хэрэг 89 нэгжээр буюу 52.4 хувиар өсч, холбогдогчдын тоо 14 нэгжээр буюу 6.25 хувиар тус тус буурсан байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой илрүүлэлт өсч, гаралт буурсан бөгөөд эд мөрийн баримтаар хурааж авсан бодисын хүн/тунг хэмжээ 37,923 буюу 5.7 дахин өссөн ба нийт 54,180 хүн/тунг хураан авч хууль бус хэрэглээг таслан зогсоосон.</p> <p>Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментаас жил бүр гаргадаг Хүн наймаалах асуудлын төлөв байдал /Trafficking Person Report/-ын тайланд улс орнуудыг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр нөлөөг 1-ээс 3 түвшинд үнэлдэг.</p> <p>“Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжихээс өмнө буюу 2017 онд Монгол Улсыг хүн наймаалах асуудлын төлөв байдлыг анхаарал татсан орны (2-оос 3 түвшинд шилжих хүлээлгийн буюу саарал) жагсаалтад байсныг 2018 оноос зэрэглэл ахиулан 2 дугаар шатлал руу дэвшин оруулж, одоог хүртэл шатлалдаа тогтвортой байна.</p> <p>Хохирогчоор тогтогдсон 91 иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлэн, зөрчигдсөн эрх ашгийг нь хангахад чиглэсэн цогц арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлыг нь гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх байдалд ахиц, үр дүн гарсан.</p> <p>Гадаад улсад хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон, тусламж хүссэн иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор эх оронд нь аюулгүй буцааж авчирсан хохирогчдын тоо өссөн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
7.3.8	Нийслэл, орон нутгийн төвүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан	-	Олон улс, улсын чанартай авто замын 60 цэгт	2020 он	-	2022 он 60	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/237 дугаар тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсэгт 2 алба хаагч ажиллаж, ажлын хэсгийн даалгаврыг гүйцэтгэж байна.

	<p>сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож, мэдээлэл, харилцаа холбоо, барилга байгууламжийн дэд бүтцийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.</p>		<p>камерын хяналтын систем суурилуулж, нэгдсэн хяналтын төв байгуулсан байна.</p>			<p>Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагын нэгдсэн “Дата төв”, “Видео аналитик, платформ систем”, “Ханан дэлгэцийн систем”, Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж” болон “Орон нутгийн хатуу хучилттай авто зам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэг /пост/-ийг камерын систем бүхий “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн барилгын зураг, төслийг хийхэд шаардагдах 350.0 сая төгрөгийн зардлыг Барилга хот, байгуулалтын сайдын багцаас шийдвэрлүүлэн, тендерт “Барилга байгууламж” ХХК шалгарч, барилгын зураг төслийг боловсруулсныг Барилгын хөгжлийн төвөөр баталгаажуулсан.</p> <p>“Бүгд Найрамдах Солонгос Улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/-ын 10.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл”-ийн саналд ирүүлсэн загвар маягтын дагуу төслийн танилцуулга 33 хуудас материалыг бэлтгэж, англи хэл дээр орчуулан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2022 оны 01/254 дугаартай албан бичгээр хүргүүлж, хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулах санал хүргүүлэхийг хүссэн.</p> <p>Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулахад шаардлагатай 737.2 тэрбум, цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбоог шинэчилж, хэт богино долгионы тоон Р-25 систем нэвтрүүлэх 75,1 тэрбум төгрөгийг тус тус 2023 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/267 дугаар албан бичгээр хүргүүлсэн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй.</p> <p>Олон улсад хэрэгжиж буй “Green zone” төслийн хүрээнд Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны 19.7 га газрын 61 цэгт 145 камер шинээр байршуулах, түүнд шаардагдах төсөв тооцоонд тулгуурлан төр, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хамтын санхүүжилтын дэмжлэгтэйгээр камер суурилуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
--	--	--	---	--	--	--

7.3.9	Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ.	-	Төсөл хэрэгжүүлэх (тоогоор)	2021	-	2022 1	<p>Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын дэргэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил болон донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, түүний хор аюулын талаар зорилтот бүлэг болох энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон ял шийтгэгдсэн, суллагдсан болон нийт иргэд, өсвөр үеийн залуучуудад ухуулга нөлөөллийн сургалт зохион байгуулах зорилго бүхий “Сургалт, мэдээллийн төв”-ийг 2019 онд байгуулж, үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдогчдын 55.0 хувийг 13-25 насны хүүхэд, залуучууд эзэлж байгаа тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, тэдний эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтнуудад мэдлэг олгох зорилгоор ухуулга нөлөөлөл, мэдээлэл, сурталчилгааны “Хасах 25” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Төслийн хүрээнд “Анзаар” аян, арга хэмжээг зохион байгуулж, төрийн болон төрийн бус 118 байгууллагын 8046 ажилтан, 18 их, дээд сургуулийн 317 багш, 2795 оюутан, ерөнхий боловсролын 82 сургуулийн 1830 багш, нийгмийн ажилтан, 7569 эцэг, эх асран хамгаалагч, нийт 20557 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар мэдлэг олгох сургалт, мэдээллийн ажлыг танхимаар зохион байгуулж, хор уршиг, үр дагавар, хууль эрх зүйн мэдээлэл өгөх агуулга бүхий 21300 ширхэг гарын авлага бэлтгэн тараасан.</p> <p>Тайлбар:</p> <p>Цагдаагийн албаны тухай хуулиар “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналт тавих чиг үүрэгтэй” бөгөөд мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх ажлыг Эрүүл мэндийн байгууллагаас хариуцан зохион байгуулахаар байх тул хэрэгжилтийг тайлагнах</p>
-------	---	---	-----------------------------	------	---	-----------	---

							байгууллагаас цагдаагийн байгууллагыг хасуулах саналтай. /Хэрэгжилт-100%/
7.3.10	Улаанбаатар хотод төвлөрсөн, орон нутаг дахь цагдаагийн байгууллага бүрд стандартын шаардлага хангасан эрүүлжүүлэх байрыг үе шаттайгаар барьж ашиглалтад оруулна.	Улсын төсөв 1,273.1	Стандартын шаардлага хангасан эрүүлжүүлэх байр (тоогоор)	2021	1	2022 он 1 /нийт 2/	<p>Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 37¹ эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа явуулж байгаа ба “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, ерөнхий шаардлага” MNS5527:2019 стандарт хангаагүй 18² байна.</p> <p>Байрны хонгилд байрладаг, прокурорын байгууллагаас шаардлага авч байсан 5³ аймагт шинээр эрүүлжүүлэх байр барих саналыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу 01/490 дугаар албан бичгээр саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч 2023 оны улсын төсөвт тусгагдаагүй.</p> <p>Нийслэлийн баруун бүсэд баригдах эрүүлжүүлэх төвийн газрыг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/883 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Морингийн даваа орчимд 23350м² газрыг 15 жилийн хугацаатай эзэмших эрх олгож, бүртгүүлж, гэрчилгээ⁴ авсан.</p> <p>Нийслэлийн зүүн бүсэд Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа нээлттэй хорих 421 дүгээр ангийн эзэмшлийн 6.800 м.кв газрыг шилжүүлэн олгох асуудлыг уламжлан шийдвэрлүүлэх хүсэлтийг энэ оны 01/293 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.</p> <p>Эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин нөхцлийг сайжруулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг дээшлүүлэх чиглэлээр 9⁵ байранд улсын төсвөөс 10.6 сая, 3 байранд орон нутаг болон бусад төсвөөс 229.7, нийт 240.4 сая төгрөгөөр засвар үйлчилгээ, гал тогоо, хими цэвэрлэгээний тоног төхөөрөмж олгосон.</p>

¹ Нийслэлд 9, 21 аймагт тус бүр 1, сум дундын цагдаагийн хэлтэст 7.

² Баянзүрх, Баянгол, Хан-Уул дүүрэг, Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Шарын гол, Замын -Үүд, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Мандал, Сайхан, Хэнтий аймаг.

³ Архангай, Булган, Говьсүмбэр, Хэнтий, Өвөрхангай аймаг.

⁴ Э-2206007634.

⁵ Сонгинохайрхан дүүрэг, Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл аймаг.

							<p>Архангай аймаг дахь цагдаагийн газрын барилга, эрүүлжүүлэх, түр саатуулах байрны 2 блокыг 5.4 тэрбум төгрөгөөр 2022-2023 онд бариулах ажил явагдаж байна.</p> <p>Тайлбар:</p> <p>Дэлхийн эдийн засгийн хямралт нөхцөл байдал, Монгол Улс хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотойгоор Монгол Улсын төсөвийн хөрөнгөөр санхүүжүүлэх шинэ төсөл, арга хэмжээг хязгаарлаж, өмнөх онуудын хэрэгжүүлж дуусаагүй төсөл, арга хэмжээг дуусгахаар төлөвлөсөнтэй холбогдуулан шинээр барих 4 эрүүлжүүлэх байрны санхүүжилт улсын 2023 оны төсөвт тусгагдаагүй.</p> <p>Төслийн хэрэгжилтэд Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагаанаас шалтгаалсан удаашрал байхгүй, оролцоогоо бүрэн хангаж, төслийн хариуцагчаас даалгасан ажил, үүргийг тухай бүр гүйцэтгэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
7.3.12	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдын ашиглах төхөөрөмжийг шинэчилж, сайжруулна.	2,876.4 /Улсын төсвөөс 2,601,1 НИТХ 350,0/	Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулсан хөрөнгө (сая төгрөг)	2020	0	2022 он 2,876.4	<p>Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполоос 6 нэр төрлийн 53 багц хар тамхи, тэсэрч дэлбэрэх бодис тест, гар утаснаас тоон ул мөр илрүүлэх, шинжлэх “Mobile device extractor tool Hancom WITH-MD-NEXT” программын 1 жилийн ашиглалтын эрх бүхий Dongle төхөөрөмж, Бүгд Найрамдах Чех Улсын галт зэвсэг үйлдвэрлэгч “Ceska zbrojovka” байгууллагаас шинэ загварын 6 ширхэг галт зэвсгийг тус тус тусламжаар илрүүлснийг хүлээлгэн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Цагдаагийн байгууллагын 2022 оны урсгал зардлаас суурин компьютер 546, зөөврийн компьютер 46, хэвлэгч 73, гар станцэы чихэвч 303, “Драйгер-7510” загварын согтуурал хэмжигч багажийн нэг удаагийн хошуу 10000, 9 нэр төрлийн 117 ширхэг нэг бүрийн болон хамгаалах тухай хэрэгсэл, таблет 280, хэт богино долгионы дахин дамжуулах станц 2, сүлжээний 15 нэр төрлийн тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдал, технологийн үйл ажиллагаанд ашиглагдах программ хангамж, лицензийг худалдан авч олгосон.</p> <p>Автопарк шинэчлэх ажлын хүрээнд улсын төсвийн санхүүжилтээр 1, урсгал зардлаас 8, нийт 9 ширхэг</p>

							автомашиныг 414.4 сая төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаанд ашиглаж байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
7.3.13	Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн боомтыг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд (перкурсор)-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохойн сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.	Улсын төсөв 1.7	Албаны нохойн тоног, хэрэгслийн шинэчлэлт (хувиар)	2021	0	2022 3%	Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд 41 албаны нохой ашиглаж байгаагаас 2 лабродар, 1 малиуна, 2 Белигийн малиноз, нийт 3 үүлдрийн 5 нохойг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдийг таних, илрүүлэх чиглэлээр 2016 оноос эхлэн сургаж албанд ашиглаж байна. Лондоны амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй “Монгол Улсын Эрэлч нохойн албыг чадавхжуулах” төслийн хүрээнд 1,7 сая төгрөгийн үнэ бүхий нохойны үнэрлэх чадварыг нэмэгдүүлэх, хэргийн илрүүлэлтэд ахиц гаргах зорилгоор 2 ширхэг үржлийн нохой, лабораторийн техник, тоног төхөөрөмжийг худалдан авч, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Вест Мидландын цагдаагийн газрын Албаны нохойн сургалтын нэгдсэн төвийн Гөлөг хөгжүүлэх хөтөлбөрийн сургагч багш нар нохой ашигладаг 9 байгууллагын 20 алба хаагч, ажилтан нарт олон улсын албаны нохойг сургах сургалтын арга барил, туршлагыг танилцуулах, тэднийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Сургалт зохион байгуулснаар албаны нохойны хүчин чадлыг сайжруулж, дасгал сургуулилтад эерэгээр нөлөөлсөн, шинэ туршлага судалсанаараа ач холбогдолтой. <i>/Хэрэгжилт-100%/</i>
7.3.17	Инновацад суурилсан техник, технологийн шинэчлэлийг сайжруулж, кибер гэмт хэргээс хамааралтай цахим нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэх,	-	Техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлсэн байх. (Хувиар)	2021	10%	2022 онд 15%	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан болон Америкийн Нэгдсэн Улсын Сураггүй алба болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд туслах Олон улсын төв (ICMЕС) хамтран зохион байгуулж буй Цахим орчин дахь хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 32 мянган долларын өртөг бүхий программ хангамж, техник хэрэгслийг ⁶ , Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага /Интерпол/-аас “Лидер” төслийн хүрээнд буцалтгүй

⁶ notebook 7, телевизор 1, принтер 3, тоон ул мөр илрүүлэхэд шаардлагатай 3 программ хангамж.

	хиймэл оюун ухааныг ашиглах чадамжийг хөгжүүлж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.						<p>тусламжаар олгож байгаа гар утаснаас тоон ул мөр илрүүлэх, шинжлэх “Mobile device extractor tool Hancom WITH-MD-NEXT” программын 1 жилийн ашиглалтын эрх бүхий Dongle төхөөрөмжийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Гэмт хэрэг, зөрчилд ач холбогдол бүхий тоон ул мөрийг бэхжүүлэх тухай прокурорын байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдээс ирүүлсэн 121 тоног төхөөрөмж, 90 цахим хаягт үзлэг хийж хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нийт 235 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 112 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналтай Прокурорын байгууллагад шилжүүлж шийдвэрлэсэн.</p> <p>Тоон ул мөр илрүүлэх лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын жишигт хүргэх зорилгоор хэрэгцээ, шаардлага, ач холбогдол, зарим шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа, саналыг энэ оны 01/506, 2/354 дүгээр албан бичгээр 2 удаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн газрын төлөөлөгч нартай хийсэн уулзалтаар мансууруулах бодистой тэмцэх чадавхыг бэхжүүлэх, цахим шинжилгээний лаборатори байгуулах асуудлыг дэмжиж, шаардлагатай төсөв хөрөнгийн талаар судалгаа хийж, хариу мэдэгдэхээр болсон.</p> <p>Олон Улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага Интерполын төв товчооноос эрхлэн гаргасан тоон ул мөр илрүүлэхтэй холбоотой “INTERPOL_DFL_Global Guidelines Digital Forensics Laboratory” 85 хуудас эмхэтгэлийг орчуулж дуусган, редактарлах ажил хийгдэж байна.</p> <p>/Хэрэгжилт-100/</p>
7.3.18	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх нэгжийн бүтэц, орон тоог өргөжүүлж,	Улсын төсөв 44.15	соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бүтцийг бий болгох	2021	-	2022 Нэгж бий болгоно.	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/315, 2022 оны А/205 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд “Түүх соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх тасаг”-ийг 5

	<p>чадавхыг нэмэгдүүлэх, уг гэмт хэргийн улмаас хууль бусаар гадагш гарсан хөрөнгийг царцаах, буцаан авах талаар хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалт, мэдээлэл солилцох арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.</p>				<p>орон тоотой байгуулан, цол цалингийн зэрэглэлийг баталж⁷, алба хаагчийг томилсон.</p> <p>Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан 1 эрдэм шинжилгээний хурал, 3 уулзалт зөвлөгөөн, 3 сургалтад давхардсан тоогоор 116 алба хаагчийг хамруулсан. Алба хаагчдыг сургалт, зөвлөгөөнд хамруулснаар тэдний соёлын өвийг хамгаалах мэдлэг ойлголт, онцлог, ялгаа, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой болсон.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/284 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны III хэлтсийн бүтцэд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг байгуулагдаж одоогийн байдлаар тасгийн дарга 1, эрүүгийн ахлах мөрдөгч 2, эрүүгийн мөрдөгч 2 орон тоогоор нэмэгдүүлж, нийт 5 алба хаагч улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.</p> <p>Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн ажлын албанаас худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий нэгжийн алба хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор 5⁸ улс, дотоодод зохион байгуулагдсан хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөх арга тактикийг судлах, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдсан урт болон богино хугацааны сургалтуудад алба хаагчдыг хамруулан гэмт хэрэг илрүүлэх, хохирогчийг олж тогтоох чадавхыг бэхжүүлсэн.</p> <p>Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах, гэмт хэргийн улмаас хулгайлагдсан хөрөнгийг олж тогтоох чадавхыг дээшлүүлж, мэргэшүүлэх чиглэлээр гадаад улсаас цахимаар зохион байгуулсан 9 удаагийн сургалтад 64 мөрдөгч, дотоодод зохион байгуулсан 18 удаагийн</p>
--	---	--	--	--	--

⁷ дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, эрүүгийн ахлах мөрдөгч 1, эрүүгийн мөрдөгч 2

⁸ Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солнгос Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улс, Тайландын Хант Улс, Сингапур улс.

							сургалтад давхардсан тоогоор алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 217 мөрдөгчийг хамруулсан. /Хэрэгжилт-100%/
Зорилт 7.4. Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.							
7.4.4.	Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.	-	Алба хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая төгрөг)	2020	243.0 тэрбум	2022 251.1 тэрбум	<p>Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэг болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын цалинг нэмэгдүүлэх тухай 3 хувилбар бүхий саналыг боловсруулж “Тогтоолд нэмэлт оруулах тухай” хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 1/5617 дугаартай албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2014 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 99 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/88 дугаар тушаалаар Мэргэжлийн зэргийн шалгалт авах Ажлын хэсгийг байгуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас мэргэжлийн зэргийн шалгалт авч, тэнцсэн 1248 алба хаагчид энэ оны 06 дугаар сараас эхлэн “мэргэшлийн зэргийн нэмэгдэл”-ийг сарын үндсэн цалингийн 5-25 хувиар нэмэгдүүлж олгож байна.</p> <p>Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн алба хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, энэ оны 05 дугаар сарын 01-ээс энгийн ажилчдын цалингийн доод хэмжээг өөрчлөн олгож байна.</p> <p>/Хэрэгжилт-100%/</p>
7.4.5.	Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, ахмад настан, хөгжлийн	-	Хаяг байршлыг нарийвчлалтай, шуурхай тогтоох	2020	Үйл ажиллагаанд нэвтрүүлэх судал-	2022 Үйл ажиллагаанд нэвтрүүлэх	<p>Өөрийн хаяг, байршлаа мэдэхгүй байгаа иргэнд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын “What3words” компанитай 2021 онд “Санамж бичиг”-ийг байгуулж, “3 үгт хаяг”-ийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд уг программыг ашиглан</p>

	<p>бэрхшээлтэй болон бусад иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгож, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эмнэлгийн түргэн тусламжийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангана.</p>		<p>what3words буюу 3 үгт програмыг нэвтрүүлэх.</p>		<p>гаа хийх.</p>	<p>энэ онд хаяг байршлаа тодорхойлж чадахгүй 3 иргэн /ууланд төөрсөн 1, бусдын эрхшээлд автан барьцаалагдсан 2/-д яаралтай тусламж үзүүлж, авран хамгаалсан байна.</p> <p>Тусгай дугаарын утсаар гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын 476.932 гал түймэр, гамшиг ослын 3.902, эмнэлгийн түргэн тусламжийн 286.201 дуудлага, мэдээллийг хүлээн авч, бүртгэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага болон гал унтраах аврах анги, түргэн тусламжийн төвд тус тус дамжуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>Утсаар залгаж яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл өгөх боломжгүй нөхцөл байдалд орсон /гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, барьцаалуулсан гэх мэт гэмт/ иргэнээс дуудлага хүлээн авах боломжийг бүрдүүлэх зорилгоор яаралтай тусламжийн EIN системд өргөтгөл хийж, бүх иргэдээс богино зурвас /мессеж/-аар дуудлага мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлж 2021 онд үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд 2021 онд 205, 2022 онд 137, нийт гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 342 дуудлага, мэдээллийг хүлээн авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад шуурхай дамжуулсан ба одоогийн байдлаар тусгай дугаарын 103, 101, 105 дугаарын утсаар иргэдээс богино зурвасаар ирүүлсэн дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй байна.</p> <p>Эмнэлэгийн түргэн тусламжийн 103 дугаарын дуудлагын ачааллыг бууруулах, түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай дамжуулах зорилгоор “Монголын цахилгаан холбоо” ХК-тай 2010 онд байгуулсан “Монголын цахилгаан холбоо ХК-ийн сүлжээ, станцид холбогдон ажиллах холболтын гэрээ”-г энэ оны 04 дүгээр сарын 27-ны өдөр шинэчлэн байгуулж, хүүхдийн өвчлөлтэй холбоотой дуудлагыг 70xxxxxx-тай дугаарыг ашиглан хүлээн авах техникийн нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100/</p>	
7.4.6.	Салбарын алба хаагчдын дүрэмт хувцас, зэвсэг, тусгай	-	Арга хэмжээний хэрэгжилт	2021	10 %	2021 он 100%	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн”-тэй 2020 онд байгуулсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр Монгол

	хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар, стандартыг судлан тогтоож, лаборатори, үйлдвэр байгуулна.		(хувиар)		Салбарын алба хаагчдын дүрэмт хувцас, зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанарын шаардлагыг стандартын төслийг боловсруулах	Стандартыг батлуулах	Улсын Засгийн газрын 2017 оны 155, 2019 оны 431, 2021 оны 17 дугаар тогтоолоор баталсан цагдаагийн алба хаагчийн 6 бүлгийн 68 нэр төрлийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг материалд тавигдах доорх 11 багц стандартыг боловсруулж, Стандартчилал, хэмжил зүйн газраар “Байгууллагын стандарт” болгон батлуулав. Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын ашиглаж байгаа сумны нөөцийг бага зардлаар бүрдүүлэх зорилгоор Америкийн нэгдсэн улсын “Mark 7R reloading” LLC байгууллагатай галт зэвсгийн хонгиог дахин цэнэглэх “Mark 7 Evolution” сум угсрагч загварын бүрэн автомат төхөөрөмж, “Hornady ammo plant”, “The evolution” загварын 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс санхүүжүүлсэн хөрөнгөөр худалдан авч, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Сум дахин цэнэглэх цехийн үйл ажиллагаа явуулах, тоног төхөөрөмж байрлуулах өрөөг тусгай зориулалтын дагуу тохижуулан засвар хийсэн. /Хэрэгжилт-100%/
7.4.7.	Салбарын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг шаттайгаар шинэчилнэ. үе	2,142,100.0 /Улсын төсвөөс 49.0, Урсгал зардлаас 460.3 Бусад зардлаас 1,681.8 /	Автопарк шинэчлэлт (хувиар)	2020	0%	2022 он 35% Одоо ашиглагдаж байгаа автомашины парк шинэчлэлт	Автопарк шинэчлэх ажлын хүрээнд улсын төсвийн санхүүжилтээр 1, урсгал зардлаас 8, нийт 9 ширхэг автомашиныг 414,4 сая төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн 6 иж бүрдэл мотоцикл, 7 төрлийн 17 ширхэг автомашиныг 2,1 тэрбум төгрөгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. 2020 оноос хойш цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа автомашины 40 орчим хувийг шинэчлээд байна. /Хэрэгжилт-100%/
7.4.30	Хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ.	-	Арга хэмжээний хэрэгжилт (хувиар)	2020	0	2021 он 10%	Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан “Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль”-д генетик болон биометрик мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах төрийн байгууллага,

						/судалгаа хийнэ/	энэ төрийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зорилгыг тодорхойлсны дотор цагдаагийн байгууллага байхгүй. Хэрэгжилтийг тайлагнах байгууллагын жагсаалтаас цагдаагийн байгууллагыг хасах саналтай.
7.4.31	Дараа үеийн суурин болон хөдөлгөөнт холбооны технологийн дэвшилд тулгуурласан цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон харилцаа холбооны шийдлийг нэвтрүүлнэ.	-	Арга хэмжээний хэрэгжилт (хувиар)	2020	0	2024 он 20% /судалгаа хийнэ/	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/237 дугаар тушаалаар байгуулсан “Төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын хэт богино долгионы радио станцуудыг шинэчлэх, нийслэл, орон нутгийн авто зам, уулзвар, гарц, хяналтын цэгүүдэд дэвшилтэт технологи бүхий теле хяналтын камер суурилуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нэгдсэн удирдлага бүхий хяналтын ухаалаг систем нэвтрүүлэх чиглэлээр судалгаа гаргах, төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог тодорхойлоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсэг”-ээс өгсөн үүргийн дагуу “Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчлэх” төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа тусгайлсан чиг үүргийн байгууллага /ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ШШҮХ/-уудын радио холбоог нэгдсэн нэг системээр шинэчлэх төсөл болгож боловсруулан, төслийн хамрах хүрээ нэмэгдсэнтэй холбоотой нэгдсэн тооцоо, судалгаа, танилцуулгыг бэлтгэж, 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэд хүлээлгэн өгсөн. Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчилж, хэт богино долгионы тоон Р-25 системийн 75,1 тэрбум төгрөгийг 2023 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/267 дугаар албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр төслийг Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар, “Моторола сольюшн” компанитай хамтран хэрэгжүүлэх, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газраас олгох 10,0 сая ам.долларын санхүүжилтээр эхний ээлжинд Улаанбаатар хотод үндсэн дэд бүтцийн суурийг 60 хувьтай байгуулж, цагдаагийн байгууллагын хэрэгцээт станцын 30 хувьд нөхөн хангалт хийхээр төлөвлөснийг мэдэгдсэн ба

							<p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Сөргө-2022” стратегийн нэгдсэн команд штабын сургуулилтын үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайдын байгуулсан тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын радио холбооны нэгдсэн системийг байгуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж, танилцуулах үүрэг бүхий Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэгт алба хаагчид ажиллаж байна</p> <p>Тайлбар: Төслийн санал хүргүүлсэн боловч Дэлхийн эдийн засгийн хямралт нөхцөл байдал, Монгол Улс хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотойгоор Монгол Улсын төсөвийн хөрөнгөөр санхүүжүүлэх шинэ төсөл, арга хэмжээг хязгаарлаж, өмнөх онуудын хэрэгжүүлж дуусаагүй төсөл, арга хэмжээг дуусгахаар төлөвлөсөнтэй холбогдуулан улсын 2023 оны төсөвт санхүүжилт тусгагдаагүй.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
Зорилт 7.5. Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно.							
7.5.1	<p>Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах халдлагыг илрүүлэх, таслан зогсоох чадавх бий болгож, кибер гэмт хэрэгтэй тэмцэнэ.</p>	-	<p>Хүргүүлсэн мэдэгдэл (тоогоор)</p>	2021	-	<p>2022 он 11</p>	<p>Шинээр батлагдан гарсан Монгол Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг судлан үйл ажиллагаандаа мөрдөж байна.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны А/366, 2014 оны А/571, 2015 оны Б/251, 2017 оны А/23, 2018 оны А/152, 2020 оны А/223, 2022 оны А/205, А/206 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг 42⁹, Мөрдөн байцаах албаны Кибер гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг 17¹⁰ орон тоотой тус тус байгуулан, цол цалингийн зэрэглэлийг баталж], алба хаагчийг томилсон.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>

⁹ Хэлтсийн дарга 1, тасгийн дарга 2, чиглэлийн ахлах мөрдөгч 4, шинжээч-чиглэлийн ахлах мөрдөгч 1, эрүүгийн ахлах мөрдөгч 12, шинжээч-эрүүгийн ахлах мөрдөгч 2, эрүүгийн мөрдөгч 18, шинжээч-эрүүгийн мөрдөгч 2.

¹⁰ Хэлтсийн дарга 1, ахлах мөрдөгч 2, мөрдөгч 14.

7.5.2	Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацыг ашиглах чадавхыг дээшлүүлнэ.		Соён гэгээрүүлэх ажил (тоогоор)	2021	10	2022 15	<p>Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Воронеж хотын Дотоод хэргийн дээд сургуулиас зохион явуулсан "Харилцаа холбооны системийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нягтлан бодох бүртгэл, мэдээллийн систем дэх харилцаа холбоог хамгаалах" сэдэвт цахим сургалтад 2 алба хаагч хамрагдсан.</p> <p>Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын хөгжлийн агентлагийн /USAID/ захиалгаар Тайланд улсын Love Prankie маркетингийн агентлагтай хамтран олон нийтийн дунд цахим аюулгүй байдлын талаар ойлголттой болгох "Миний Минийх" компанит ажлыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа "Вайрал Партнерс" ХХК-тай хамтран цахим орчин дахь хүүхдийн хүчирхийллийн эсрэг гэмт хэргийг бууруулах зорилго бүхий "Аюулгүй интернэт" уриатай урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд автобусны буудал дээр постер байрлуулж, урьдчилан сэргийлэх контентыг цахим орчинд байрлуулжсан.</p> <p>Кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, их, дээд сургуулийн оюутан, сурагчдад сургалт зохион байгуулах ажлын хүрээнд улсын хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 115 байгууллагын 2560 орчим алба хаагч, ажилтан, иргэд, оюутан, сурагч нарт Кибер гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, цаашдын хандлага, өөрийн хувийн мэдээллийг хэрхэн хангах зэрэг 15 сэдвийн хүрээнд 3114 цагийн сургалт зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
7.5.3	Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг	-	Тоон ул мөр илрүүлэхтэй холбоотой гадаад улсын туршлага судлах (Хувиар)	2021	30%	2022 40%	<p>Олон Улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага Интерполын төв товчооноос эрхлэн гаргасан тоон ул мөр илрүүлэхтэй холбоотой "INTERPOL_DFL_Global Guidelines Digital Forensics Laboratory" эмхэтгэлийг орчуулж, хянуулж байна.</p> <p>Тус байгууллагаас зохион байгуулж байгаа "Leader" төслийн хүрээнд гишүүн орнуудын цагдаа, хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын чадавхыг сайжруулах,</p>

	хөгжүүлж, кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын ба бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэнэ.						тоон ул мөр илрүүлэх, бэхжүүлэх цахим сургалтад 2 алба хаагч хамрагдан дадлагажиж байна. Фэйсбүүк орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор америкийн нэгдсэн Улсын “Фэйсбүүк” компанийн төлөөлөлтэй 5 удаагийн албан ёсны уулзалт, цахим хурлыг зохион байгуулж, хамтран ажиллах чиглэлээр үр дүнтэй харилцааг үүсгэн мэдээлэл солилцох ногоон сувгийг бий болгосон. Бүгд Найрамдах Турк Улсын ТИКА-гийн Улаанбаатар хот дахь хөтөлбөр зохицуулалтын газраас мэргэшүүлэх сургалтын төслийн хүрээнд Бүгд Найрамдах Турк Улсад зохион байгуулагдсан “Дижитал нотлох баримт, зураг авалтад анхан шатны оролцоо” сэдэвт сургалтад 5 алба хаагч хамрагдаж, туршлага солилцсон. <i>/Хэрэгжилт-100%/</i>
7.5.6	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлнэ,	-	Иргэдэд хүргэсэн сэрэмжлүүлэг , мэдээлэл (тоогоор)	2021	50	2022 60	Кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, их, дээд сургуулийн оюутан, сурагчдад сургалт зохион байгуулах ажлын хүрээнд улсын хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 115 байгууллагын 2560 орчим алба хаагч, ажилтан, иргэд, оюутан, сурагч нарт Кибер гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, цаашдын хандлага, өөрийн хувийн мэдээллийг хэрхэн хангах зэрэг 15 сэдвийн хүрээнд 3114 цагийн сургалт зохион байгуулсан. “Кибер орчинд бусдын нэр хүндэд халдаж, гүтгэн доромжлохгүй байх” зэрэг сэдвийн хүрээнд богино хэмжээний /шторк/ 29 дүрс бичлэг, кибер гэмт хэргийг илрүүлсэн талаар 73 мэдээлэл, Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой үүсэж болзошгүй гэмт явдлаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл 107-г тус тус бэлтгэн давхардсан тоогоор нийт 7,858,000 хэрэглэгчдэд хүргэж, түгээж ажилласан. Хэвлэлийн бага хурал 48 удаа хийж, нийслэл, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны болон олон нийтийн 67 телевиз, 16 ФМ радио, 14 сонин, 81 сайтад кибер гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл, сурвалжлага олон нийтэд хүргэсэн.

							/Хэрэгжилт-100%/
7.5.9	Кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын ба бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэнэ.		Гадаад улсын туршлага судлах сургалтад алба хаагчдыг хамруулах (тоогоор)	2021	2	2022 5	Бүгд Найрамдах Турк Улсын ТИКА-гийн Улаанбаатар хот дахь хөтөлбөр зохицуулалтын газраас мэргэшүүлэх сургалтын төслийн хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 23-27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсад зохион байгуулагдсан “Дижитал нотлох баримт, зураг авалтад анхан шатны оролцоо” сэдэвт сургалтад 5 алба хаагч хамрагдаж, туршлага солилцсон. БНСУ-ын Үндэсний цагдаагийн газраас Монгол Улсын цагдаагийн байгууллагын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр мансууруулах бодисын цахим мэдээллийн систем боловсруулж суурилуулах, мансууруулах бодис илрүүлэх зарим тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 03-ны өдрүүдэд Монгол Улсад судалгаа хийхээр ирсэн төлөөлөгчдөд цахим шинжилгээний лаборатори байгуулах хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулга, мэдээлэл хийж БНСУ-ын Үндэсний цагдаагийн газраас цахим шинжилгээний лаборатори байгуулах асуудал дээр дэмжиж, шаардлагатай төсөв хөрөнгийн талаар судалгаа хийж, хариу мэдэгдэхээр болсон.
7.5.10	Нийгмийн сүлжээ, цахим хуудас, телевизийн нэвтрүүлэг, нийтлэл хэлбэрээр дамжуулан олон нийтийн цахим мэдлэг боловсролыг дээшлүүлэн интернэтийн зохистой, соёлтой хэрэглээг нийтэд төлөвшүүлж, кибер орчинд хүний эрх, эрх чөлөөг	-	Урьдчилан сэргийлэх богино хэмжээний шторк хийх (тоогоор)	2021	-	2022 20	/Хэрэгжилт-100%/ Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэх, сэрэмжлүүлэг өгөх зорилгоор: -Кибер орчинд бусдын нэр хүндэд халдаж, гүтгэн доромжлохгүй байх” зэрэг сэдвийн хүрээнд богино хэмжээний /шторк/ 29 дүрс бичлэг, -Кибер гэмт хэргийг илрүүлсэн талаар 73 мэдээлэл, -Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой үүсэж болзошгүй гэмт явдлаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл 107-г тус тус бэлтгэн давхардсан тоогоор нийт 7,858,000 хэрэглэгчдэд хүргэж, түгээж ажилласан. -Хэвлэлийн бага хурал 48 удаа хийж, нийслэл, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны болон олон нийтийн 67 телевиз, 16 ФМ радио, 14 сонин, 81 сайтад

	хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.						кибер гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл, сурвалжлага олон нийтэд хүргэсэн. <i>/Хэрэгжилт-100%/</i>
7.5.25	Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах халдлагыг илрүүлэх, таслан зогсоох чадавх бий болгож, кибер гэмт хэрэгтэй тэмцэнэ.		Тоног төхөөрөмж, цахим хаягт үзлэг хийсэн тоо	2021	Тухай бүр	Тухай бүр	Гэмт хэрэг, зөрчилд ач холбогдол бүхий тоон ул мөрийг бэхжүүлэх тухай прокурорын байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдээс ирүүлсэн албан бичгийн дагуу 47 тоног төхөөрөмж, 26 цахим хаягт үзлэг хийж хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 204 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 99 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналтай Прокурорын байгууллагад шилжүүлж шийдвэрлэсэн. Шалгаж шийдвэрлэсэн хэрэгт дүн шинжилгээ хийж гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцлийг судлан, гарсан зөрчлийг арилгуулахаар 8 аж ахуйн нэгж, байгууллагад 11 мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлж, 6 мэдэгдлийн хариуг авсан. <i>/Хэрэгжилт-100/</i>
Тайлбар: Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагаанаас шалтгаалсан удаашрал байхгүй, оролцоогоо бүрэн хангаж, төслийн хариуцагчаас даалгасан ажил, үүргийг тухай бүр гүйцэтгэн ажиллаж байна.							

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР